



## НОГООННУУР СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл  
дараах хаягаар харилцана уу:**

Баян-Өлгий аймгийн  
Аудитын газар

Тэргүүлэх аудитор  
М.Хуанган  
Утас:70422954  
Цахим хаяг: mhkuangan@yahoo.com

Аудитын менежер:  
Х.Женисбек  
Утас: 70422930  
Цахим хаяг: : jekbay01@yahoo.com

Аудитор: Б.Үүрийнтуяа  
Утас: 89838414  
Цахим хаяг: Elbegeeuuree@yahoo.com

**Хаяг:** Баян-Өлгий аймаг дахь  
Төрийн аудитын газар

**Байршил:** Өлгий сум, 5-р баг,  
Аймгийн ЗДТГазрын байр, 1-р  
давхар  
**Цахим хуудас:** [www.bayan-ulgii.tvet.gov.mn](http://www.bayan-ulgii.tvet.gov.mn)

**2018 оны 2 дугаар сар**

### Аудитын тайлан

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

## АГУУЛГА

---

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Зөвлөмж
17. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

### **Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:**

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.2.1 дэх заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дүгээр зүйлд заасан аймаг дах Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Ногооннуур сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд /БӨА-2018/52-СТА-ТШЗ/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Ногооннуур сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2017 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Ногооннуур сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2018 оны 2 дугаар сарын 19-нөөс 2 дугаар сарын 25-ны хооронд хийхээр төлөвлөн хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Ногооннуур сумын Хүүхдийн цэцэрлэг 2017 оны санхүүгийн тайланг 2018 оны 1 дүгээр сарын 26-нд аймгийн Төрийн аудитын газарт ирүүлсэн.

Аймаг дахь Төрийн аудитын газар аудитыг 2018 оны 2 дугаар сарын 23-ноос 2 дугаар сарын 26-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2 дугаар сарын 26-нд Ногооннуур сумын Хүүхдийн цэцэрлэгийн удирдлагад гардуулна.

### **Байгууллагын хууль, эрх зүйн орчин:**

Ногооннуур сумын Хүүхдийн цэцэрлэгийн төсвийн захирагч нь Монгол улсын Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Боловсролын тухай хууль, Бага, дунд боловсролын тухай хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

### **Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:**

Монгол Улсын Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д “Сургуулийн өмнөх боловсролын зорилго нь бага насны хүүхдийг өөрийн онцлог, чадвар, бүтээлч үйлээрээ хөгжин, насан туршийн боловсролын суурь чадварыг эзэмшихэд дэмжин асрах, хамгаалах, хөгжүүлэх, сургалт, үйл ажиллагаагаар сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд оршино” гэж энэ байгууллагын үйл ажиллагааны зорилтыг тодорхойлсон байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна” гэж заасан байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.18-д “төсвийн бусад байгууллагын дарга (захирал, эрхлэгч) тухайн байгууллагын төсвийн төсвийн шууд захирагч байна” гэж заасны дагуу Ногооннуур сумын Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч Төсвийн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. Ногооннуур сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2017 оны төсвийг Аймгийн ТЕЗ-ийн тусгай зориулалтын шилжүүлгийн төсвийн багцаас аймгийн төрийн сангаар дамжуулан Ногооннуур сумын төрийн сангаас олгож байна.

Төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Ногооннуур сумын Хүүхдийн цэцэрлэгийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

**Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:**

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Ногооннуур сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2017 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, төлөвлөсөн ёсоор аудитын 5 чиглэлээр 17 эрсдэлтэй асуудалд 17 горим, сорил хэрэгжүүлж, түүний үр дүнг баримтжуулав. /ТАБ-СТА-В-3.1/

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэн тэдгээрийн гол үр дүн, нөхцөл байдлыг үнэлэхэд хэрэгжүүлсэн нийт горим сорилоор алдаа, зөрчилтэйд тооцож, нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-В-4.1/

Харин аудитыг төлөвлөх шатанд эрсдэлтэй гэж тооцсон боловч, аудитын горим сорил хэрэгжүүлэх явцад алдаа зөрчилгүй нь тогтоогдсон асуудлыг ТАБ-СТА-В-4.2 маягтаар нэгтгэж, баримтжуулав.

Алдаа зөрчилтэй буюу буруу илэрхийллийн нэгтгэлээс аудитын явцад залруулах боломжтой эсэх асуудлыг ТАБ-СТА-В-4.3 маягтад шийдвэрлэж, залруулах боломжтой асуудал буюу залруулгын талаарх мэдээллийг ТАБ-СТА-В-4.4, ТАБ-СТА-В-4.5 маягтуудад нэгтгэж, баримтжуулсан.

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад тус цэцэрлэг нь санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг батлаагүй боловч Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, арга зүй, санхүүгийн тайлан бэлтгэх заавар аргачлалыг мөрдөж ажилласан байна. Энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичиг нь УСНББОУС-тай нийцсэн байна.

Ногооннуур сумын Хүүхдийн цэцэрлэгийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд “бага” буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Ногооннуур сумын Хүүхдийн цэцэрлэгийн санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг “Аколоус” санхүүгийн програмаар боловсруулан төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

#### **Дотоод хяналт:**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Ногооннуур сумын Хүүхдийн цэцэрлэгийн дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед “дунд” гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

#### **Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:**

2017 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу Аймгийн ТЕЗ-ийн тусгай зориулалтын шилжүүлгийн төсвийн багцаас Ногооннуур сумын төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Ногооннуур сумын Хүүхдийн цэцэрлэгийн төсвийн захирагч нь 2017 онд 375,1 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулжээ. Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээр 374,0 сая төгрөгийн, өөрийн орлогоос 0,1 сая төгрөгийн бүгд 375,1 сая төгрөгийн санхүүжилт авч, батлагдсан төсвийг бүрэн зарцуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлийг зардлын зүйл ангиар авч үзэхэд батлагдсан төсвийн зориулалтын дагуу зарцуулсан байна.Түлш халаалт, цэвэр бохир ус, хоолны зардлын хэмнэлтийг гэрэл цахилгааны зардлын хэтрэлтэнд бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан байна.

#### **Шилэн дансны мэдээлэл**

Ногооннуур сумын Хүүхдийн цэцэрлэгийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй. Шилэн дансны тухай хуулинд заасны дагуу [shilendans.gov.mn](http://shilendans.gov.mn) вэб сайтанд байгууллагын 2017 оны батлагдсан төсвийн мэдээллийг оруулсан байна.

ҮАГ-ын аудитын нэгдсэн төлөвлөгөөр 2017 оны 11-р сард Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт нийцлийн аудитаар тус Хүүхдийн цэцэрлэг Шилэн дансны тухай хуулийн 4-р зүйлийн 4.1.3, 6-р зүйлийн 6.1.1, 6.1.2, 6.1.3, 6.4.5, 6.4.7 дахь заалтуудыг зөрчсөн 378,5 сая төгрөгийн зөрчил илэрч албан шаардлага өгөгдөн зөрчлийг арилгаж, биелэлтийг ирүүлсэн байна.

#### **Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:**

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 5 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 17 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв. Үр дагаварыг тодорхойлж чадвал: Аудитаар санхүүгийн тайланд материаллаг нөлөө үзүүлэх алдаа зөрчлийг залруулав.

#### **Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:**

Ногооннуур сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2017 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний санхүүжилт орлого, мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, бараа материал, цалин, НДШ, ХХОАТ, гэрэл цахилгаан, халаалт, тэтгэмж, хоол зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3.1/

#### **Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:**

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Материаллаг бус дараах асуудал байна. Үүнд:

1. Хоолны зардлын батлагдсан төсвөөс бага үнэтэй түргэн элэгдэх зүйл худалдан авахад 5317,0 мянган төгрөгийг төрийн сангийн зохих зөвшөөрөлгүйгээр гүйлгэн зарцуулж, Төсвийн тухай хуулийн 42.3, 42.4 дэх заалтууд болон Сангийн сайдын 2013 оны "төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам"-ын 5.2-т "аймаг, нийслэл, сум, дүүргийн төрийн сан нь төсвийн захирагчаас ирүүлсэн саналыг судлан үзээд зөвшөөрөгдсөн зардлын бүлэг хооронд тухайн зардлын бүлгийн батлагдсан төсвийн жилийн дүнгийн 120 хувиас хэтрэхгүй, 10.0 сая төгрөг хүртэлх зохицуулалтыг хийж баталгаажуулна" гэсэн заалтыг зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь: Асуудлын бүртгэлд оруулж ТТЗ-ийн тайлангаар албан шаардлага өгөхөөр болов.

2. Тус Хүүхдийн цэцэрлэгийн 2017 оны орон тоог удирдах ажилтан 1, гүйцэтгэх ажилтан 18, үйлчилэх ажилтан 11, гэрээт 3 бүгд 33 орон тоогоор баталсанаас гүйцэтгэлээр 2014 оны 1 дүгээр сараас эхлэн 1 бүлэг нэмэгдсэнтэй холбоотой нэмэгдсэн онууд хэвээрээ ажиллаж 1 багш, 1 туслах багш илүү, Санхүүгийн алба

байгуулагдаагүйгээс 1 нягтлан бодогчийн орон тоо илүү буюу бүгд 36 орон тоогоор үйл ажиллагаагаа явуулж, цалингийн сандаа багтаан ажилласан байна.

**Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:**

Аудитын явцад залруулагдаагүй алдаа гараагүй байна.

**Анхаарал татахуйц бусад чухал асуудал:**

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

**Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:**

Ногооннуур сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад дараах дансдын тооцооллыг гүйцэд даган мөшгин шалгах боломжгүй байна. Үүнд:

Үндсэн хөрөнгө, бараа материалын биет тооллого хийх цаг хугацааны боломж гараагүй учраас гүйцэтгэлийн шалгалтаар зарим хөрөнгийг биет ажиглалтаар тоолох, цалин, НДШ, хоолны зардлын гүйцэтгэлийг нарийвчлан шалгах боломжгүй тул түүврийн аргаар үзсэн болно.

**Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:**

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн асуудлыг алдаа зөрчлийн нэгтгэл маягтаар нэгтгэж харуулав.

**Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:**

Төсвийн захирагчийн 2016 оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй, төсвийн гүйцэтгэлийн тайланд 1,1 сая төгрөгийн залруулга хийгдсэн байна.

**Зөвлөмж**

Ногооннуур сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2017 оны санхүүгийн тайланд зөвлөмж өгөх асуудал гараагүй байна.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Ногооннуур сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан 8 хуудас, хавсралтууд хуудсыг тус тус хавсаргав.

**АУДИТЫН ТАЙЛАНГ:**

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

М.ХУАНГАН

Огноо:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Х.ЖЕНИСБЕК

Огноо:

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

Б.ҮҮРИЙНТУЯА

Огноо: 2018.02.26